

Монгол улс, Уул уурхай, Уур амьсгалын өөрчлөлт Авах арга хэмжээний талаарх санаачилгууд Өөрчлөлт хийх боломж

2019.01.24



Дэлхий даяараа:

- Олон улсын компаниуд улс орон бүрт адилхан арга хандлагаар үйл ажиллагаа явуулдаггүй. Шилдэг/байгууллагын туршлагад үндэслэн, эсвэл “тухайн орны хууль, эрхзүйн орчинд нийцүүлэн” ажилладаг.
- Олон улсын зарим компаниуд шилдэг туршлагыг хэрэгжүүлэх бүрэн боломжтой ч тэр бүр хэрэгжүүлдэггүй тохиолдол байна.
- Зарим тохиолдолд төрийн өмчит/орон нутгийн өмчит компаниудын хувьд хамгийн бага стандартын дагуу үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөг.

- Өөрчлөлт хийх талаар санаачлага гарсан тохиолдолд тус үйл ажиллагаанд засгийн газар, компаниуд, олон нийт зэрэг бүх оролцогч талууд оролцох шаардлагатай.
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн мэдээлэл, уур амьсгалд дасан зохицох технологийг өрсөлдөөн бус хамтын ажиллагаа гэдэг талаас нь харах шаардлагатай.
- Нэгдсэн ойлголтод хүрэх, мэдлэг мэдээллээ хуваалцах, хамтран ажиллах, хөрөнгө оруулах, хууль эрхзүйн зохицуулалтын дэглэмийг сайжруулах талаар засгийн газар нь асуудлыг урьдчилан харах чадвартай байх шаардлагатай.

Монгол улс, Уул уурхай, Уур амьсгалын өөрчлөлт

Байгаль орчны	Өнөөгийн арга хандлага	Авбал зохих арга хэмжээ
Байгаль орчны мэдээллийн хэрэгсэл	Дан ганц (нэг нэгээрээ)	Агаар, газар, ус, биологийн төрөл зүйл бүгд хамтдаа
Агуулга	Төсөл/Орон нутаг	Өргөн хүрээнд
Хамрах хүрээ	Хууль, журмын хүрээний үйл ажиллагаа	Хууль журмын болон хууль журмын бус хүрээн дэх үйл ажиллагаа
Арга хандлага	Хариу арга хэмжээ авах	Урьдчилан харах
Үр дүн	Нөлөөллийг сааруулах	Үр дүнг тодорхойлох
Бүтэц зохион байгуулалт	Хуваагдмал	Уялдаа холбоотой
Хариуцлага/оролцоо	Агентлаг, агентлагаар	Хамтарсан үйл ажиллагаа
Гүйцэтгэлийг хэмжих	Шаардлагатай тохиолдолд	Цогц байдлаар авч үзэх

Уур амьсгалд дасан зохицох асуудлыг авч үзэх менежментийн цогц системийг бий болгох: Компаниудад дотооддоо уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг урьдчилан харах, түүнд дасан зохицох, мөн асуудлыг цогцоор нь удирдах зэрэг менежментийн зохион байгуулалтандаа өөрчлөлт хийх тухайлсан арга хэмжээ авдаг байхыг хөхиүлэн дэмжих.

- Компаний стратегийн төлөвлөгөөндөө уур амьсгалын асуудлыг тусгах, барилга байгууламжийн менежментэд тодорхой өөрчлөлт хийх зэргээр дасан зохицохтой холбоотой үүргийг тухайн байгууллагад хүлээлгэх, тухайн байгууллагад зориулсан уур амьсгалын өөрчлөлтийн гарын авлага боловсруулахад дэмжлэг үзүүлэх
- Дасан зохицлын асуудлыг дэмжих үүднээс холбогдох хууль тогтоомж/журам/бодлогод өөрчлөлт хийх, мөн удирдамжаар хангах.

Өгөгдөл цуглуулах, ашиглах, хуваалцах замаар орон нутгийн түвшинд бодит эрсдэл, боломжийг тодорхойлох, хэмжих:

- Дасан зохицлын төлөвлөлтийн нэг чухал алхам болохын хувьд дэлхийн уур амьсгалын загварыг өөрийн оронд гарч буй нөлөөлөлд тохируулан өөрчлөхөд дэмжлэг үзүүлэх
- Салбарын үйл ажиллагаанд аюул учруулахуйц түвшинд температурын болон хур тунадасын хэмжээ өөрчлөгдөх магадлалыг загварчлах зорилгоор салбарын нөлөөллийн үнэлгээг хийх (их дээд сургуулийн судлаачдыг хамруулах?).
- Одоогийн болон ирээдүйн үйл ажиллагаанд учрах эрсдлийн жагсаалт гаргахад дэмжлэг болох үүднээс уурхайн талбай тус бүрээр температурын болон хур тунадасны таамаглал хийх

Мэдээлэлд тулгуурлан арга хэмжээ авах:

- Уурхайн талбай болон ойр орчмын газар нутаг уур амьсгалын нөхцөл байдалд тэсвэртэй байх чадварыг сайжруулах дасан зохицлын стратегийг боловсруулах
- Олон нийтийг мэдээллээр хангах, онцгой байдлын үеийн төлөвлөлт хийх талаар зөвлөгөө өгөх, эдийн засгийн өсөлтийг дэмжихийн тулд уурхайн төлөвлөлтийн талаарх шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээллийг орон нутгийн засаг захиргаа болон хөгжлийн агенлагуудтай хуваалцах.
- Усны хүртээмж, биологийн төрөл зүйл зэрэг хүчин зүйлсэд нөлөөлөх нөлөөллийг үнэлэх.

Хамтын ажиллагаа:

- Холбогдох бүлгүүдэд (хэрэглэгчид, менежерүүд, бодлого боловсруулагчид) зориулсан сургалтыг зохион байгуулах замаар мэдээлэл болон холбогдох арга хэрэгсэлийг ашиглах чадавхийг бий болгох
- Уур амьсгалын загварчлал, бусад шинжлэх ухааны/техникийн үйл ажиллагаа, шилдэг туршлага, өргөн хүрээний дасан зохицлын стратегийн хэрэгжилттэй холбогдох зардлын болон бусад мэдээллийг хуваалцах, газарзүйн бүсийн хүрээнд хамтран ажиллах боломжоор хангах.
- Уур амьсгалын асуудлыг хэлэлцэх, нөлөөллийг бууруулах, дасан зохицох стратеги боловсруулах талаар харилцан суралцах үүднээс тогтмол уулзалт зохион байгуулдаг байхыг олборлох салбарын компаниудад үүрэг болгох. Хүнс, хөдөө аж ахуй, эрчим хүч, зам тээвэр зэрэг бусад салбаруудаас сайн туршлага судлах боломжтой.

Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл, боломжуудыг харгалзан үзэх зорилгоор эрсдлийг тодорхойлох үйл явцыг өөрчлөн сайжруулах: Байгууллагын эрсдлийг тодорхойлох арга барилыг сайжруулах, сааруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх явцдаа уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг харгалзан үзэх.

- Шаардлагатай арга хэмжээг аваагүйгээс үүдэх эрсдэл, зардлыг тодорхойлох
- Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдлийг байгаль орчны менежментийн систем болон олборлох салбарт хамаарах ISO 31000 зэрэг стандартын нэг хэсэг болгон авч үзэхийг дэмжих
- Олборлох салбар дахь уур амьсгалын өөрчлөлтийн эрсдлийг нийгмийн болон байгаль орчны эрсдлийн үнэлгээний үйл явцад тусгах

Уур амьсгалтай холбоотой эрсдэл болон сааруулах арга хэмжээнүүдийг төсөл хэрэгжих хугацааны аливаа бизнесийн шийдвэр гаргалтад нэгтгэн үзэх: Эрсдлийн удирдлагын нэг хэсэг болгохын хувьд төслийн амьдралын мөчлөгийн туршид ялангуяа төслийн загвар гаргах, шийдвэр гаргахаас өмнө уур амьсгалын нөлөөллийг харгалзан үзэхийг салбарын байгууллагуудад үүрэг болгох.

- “Уур амьсгалын өөрчлөлтөд бэлэн байдлын шалгуур”-ыг капиталын зардлыг батлах үйл явцад тусгах.
- Эрчим хүчний үр ашигтай байдал, хүлэмжийн хийн ялгарлал, усанд тавигдах шаардлага зэрэг техникийн үзүүлэлтүүдийг бүтээн байгуулалт хийхээр санал гаргасан бүх төсөлд харгалзан үзэх.
- Эрчим хүчний хэрэгцээний тодорхой хувийг (жишээ нь 20%-ийг) нөхөн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангахыг санал болгох.

Барилга байгууламжийн стандарт, инженерийн загварчлалын найдвартай байдлыг хангах:

Олборлох салбарын хөрөнгө, дэд бүтцийг цаг агаарын эрс тэс нөхцөл байдал, үерийн аюул зэрэгт тэсвэртэй байхад анхаарах.

- Байгууламжид нөлөөлөх хуримтлагдах нөлөөллийн талаар илүү сайн ойлголттой болох үүднээс уурхайн талбайд цаг агаарын эрс тэс нөхцөл байдал үүсэх магадлал, хэмжээ, давтамжийн талаар мэдээлэл цуглуулах.

Монгол улс, Уул уурхай, Уур амьсгалын өөрчлөлт

Усны менежментийн цогц арга хэмжээг боловсруулах: Усны хангамжийг тогтвортой байлгах, эх үүсвэрийг хамгаалах замаар усыг үр ашигтай ашиглах, хэрэглээг багасгах технологиудыг хөгжүүлэх, усыг дахин ашиглах, дахин боловсруулах дэвшилтэт аргуудыг эрэлхийлэх зорилгоор усны эх үүсвэрийг шинээр олж тогтоох, тухайн усыг татах боломжийг тодорхойлоход салбарын байгууллагуудтай хамтран ажиллах.

- Усны менежментийн гол стратеги болохын хувьд ууршилтын алдагдлыг бууруулах асуудлыг эн тэргүүнд авч үзэх
- Усанд хэмнэлттэй технологийг ашиглах, далангийн усыг нөхөн сэргээх, шуурганаас үүссэн усыг цуглуулах, ашиглах
- Газрын тосны үйлдвэрлэлээс гарах усыг дахин ашиглах
- Саарал усны стандартууд
- Тухайн төсөл болон аймаг, сумын ундны усны хэрэгцээг хангалттай хүрэлцэхүйц хэмжээгээр хангах.
- Оролцоо бүхий, усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлэх замаар усны нөөцийн менежмент, хяналт-шинжилгээ, тэдгээрийг сайжруулах үйл явцад компаний зүгээс олон нийтийг татан оролцуулах.

Монгол улс, Уул уурхай, Уур амьсгалын өөрчлөлт

Үнэ цэнийг бий болгох боломж, арга хэмжээг дэмжих: Ногоон хөгжил, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлын хүрээнд байгууллагын болон олон нийтийн хэрэгцээг хангахын тулд бусад оролцогч талуудтай хамтран ажиллах, мөн орлого олох боломжуудыг эрэлхийлэх нөхцлийг бүрдүүлэх.

- Усны цэвэршүүлэх/эх үүсвэрийг шинээр бий болгосноор олборлох салбарын төсөл болон орон нутгийн үндны усны хэрэгцээг хангалттай хэмжээгээр хангах боломж бүрдэх юм.
- Уурхайд нөхөн сэргээгдэх эрчим хүчийг ашиглах, байгалийн хийн, газрын гүний, нарны, салхины эрчим хүчний байгууламжуудыг барих үйл явцыг дэмжих, цэвэр технологийн хөгжлийн механизмын хүрээнд эдгээр байгууллагуудын хүлэмжийн хийн хөнгөлөлт (кредит)-ийг нэмэгдүүлэх
- Төслийн үйл ажиллагаанд био-дизель ашиглахыг эрмэлзэх
- Нүүрстөрөгчийг илрүүлэх, хадгалалтын технологиудыг хөгжүүлэх
- Нүүрсний давхаргын метаныг олборлох үйл ажиллагааг дэмжих
- Усны хомсдол үүсч, хэрэгцээ нэмэгдэж байгаа хэдий ч компани болон олон нийтийн цэвэр усны хэрэгцээг хангах зорилгоор усны нөөцийн нэгдсэн менежментийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, орон нутгийн усны хангамжийг нэмэгдүүлэх, одоо ашиглаж байгаа эх үүсвэрийг хамгаалах зэрэгт хөрөнгө оруулах. Компаниуд усны нөөцийн нэгдсэн менежментийг оролцоог ханган хэрэгжүүлэх замаар нөөцийн удирдлага, мониторингийн үйл явцад олон нийтийг татан оролцуулж, хамтран ажиллах боломжтой.

БАЯРЛАЛАА!

